



СҮХБААТАР ДҮҮРГИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2016 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ажлыг зохицуулах зөвлөлийн 2016 оны
үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.3.3 дахь заалтыг үндэслэн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2016 үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Д.Боргио/-д даалгасугай.

ДАРГА  Б.ГАН-ЭРДЭНЭ

Сүхбаатар дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2016 оны 1 дүгээр сарын 11-ны өдрийн 01 дүгээр тогтоолын хавсралт

**ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

ЗОРИЛТ: 1. Нийтийн хэв журам хангаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

Д/д	Үйл ажиллагааны чиглэл	Хугацаа	Хэн хариуцах	Хэрэгжилт
Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар.				
1.1.	ГХУСА33-ийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ. Үүнд: Хурал-1: 1. ГХУСА33-ийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцэн батлах 2. Цагдаагийн 1,2 дугаар хэлтэс, Замын Цагдаагийн тасгийн танилцуулга	2-р сард	ГХУСА33-ийн нарийн бичгийн дарга Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, ийн Замын Цагдаагийн тасгийн дарга нар	
1.2.	Хурал-2: 1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор хороодын ГХУСА33-ийн ажлыг шалгасан тайлан, цаашид анхаарах асуудлын тухай. 2. Дүүргийн нутаг дэвсгэрт гарсан гэмт хэрэг, хэв журмын нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх ажлын тухай сонсгол.	7-р сард	Дүүргийн Прокурор, Хууль цаазын итгэмжит зөвлөх Цагдаагийн 1, 2-р хэлтсийн дарга	
1.3.	Хурал-3:	12-р сард	ГХУСА33-ийн нарийн бичгийн	

	<p>1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2016 оны тайлан.</p> <p>2. 2016 оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын тайлангийн тухай.</p> <p>3. Цагдаагийн 1,2 дугаар хэлтсийн саналын тухай.</p>		<p>дарга Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн Нийтийн Хэв журам хамгаалах тасгийн дарга нар Асуудал оруулах албан тушаалтан</p>	
1.4.	Дүүргийн ГХУСА33-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх	Тухай бүр нь	ГХУСА33-ийн ажил хариуцсан ажилтан	
1.5.	ГХУСА33-ийн хурлаар хэлэлцэх шаардлагатай асуудлыг тухай бүр хэлэлцэн шийдвэрлэж байна	Тухай бүр нь	ГХУСА33-ийн ажил хариуцсан ажилтан	
1.6.	ГХУСА33-ийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулах	2-р сард	ГХУСА33-ийн нарийн бичгийн дарга ГХУСА33-ийн ажил хариуцсан ажилтан	
1.7.	Дүүргийн нутаг дэвсгэрт гарсан гэмт хэрэг, нийтийн хэв журмын нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх талаар хийсэн ажлын тайлан мэдээллээ улирал бүр ГХУСА33-д ирүүлж байх.	Улирал бүр	Засаг даргын Тамгын газар Цагдаагийн 1, 2-р хэлтэс Замын Цагдаагийн тасаг Онцгой байдлын хэлтэс Мэргэжлийн хяналтын хэлтэс Дүүргийн Прокурорын газар	
1.8.	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагатай түншлэлийн гэрээ байгуулах, гэрээг дүгнэх, шагнаж урамшуулах	1 дүгээр улиралд	Дүүргийн Засаг дарга Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс	
1.9.	Дүүргийн Засаг дарга төсвийн ерөнхий менежерүүдтэй байгуулах үр дүнгийн гэрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хийх ажлыг тодорхой тусган өгч дүгнэх.	1 дүгээр улиралд	Дүүргийн Засаг дарга	
1.10.	Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, нийслэлийн Прокурорын газраас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2013-2016 онд хамтран хийх ажлын хөтөлбөрийн хэрэгжилтийг хороодод шалгалт хийж танилцуулах.	2-р улиралд	Дүүргийн Прокурорын газар	

1.11.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сайн ажилласан албан хаагчдыг дотоод болон гадаадын байгууллагуудаар туршлага солилцуулахаар ажиллуулах.	Жилдээ	ГХУСА33 Санал оруулсан газар, хэлтэс, тасагтай хамтран зохион байгуулна	
1.12.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор зураг хуудас хэвлүүлэх	1 дүгээр улиралд	ГХУСА33	
Хоёр. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийтлэг ажлын талаар.				
2.1.	Урамшуулалт эргүүлийн ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд /Нийтийн сонсголын тухай хууль, захиргааны ерөнхий хууль, зөрчлийн тухай, эрүүгийн хууль/ сургалт зохион байгуулах, зайлшгүй шаардлагатай материалаар хангах, нэг өдрийн ажлын нөхцөл байдлыг харуулсан зурагт хуудас гаргах, ажлын үзүүлэлтээр болзолт уралдаан зарлах.		Засаг даргын Тамгын газар Цагдаагийн 1, 2-р хэлтэс Замын Цагдаагийн тасаг	
2.2.	Гэмт хэрэг, зөрчил удаа дараа гарч буй байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага, хорооны Засаг дарга нарт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай албан мэдэгдэл хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	Жилдээ	Дүүргийн Прокурорын газар Цагдаагийн 1, 2-р хэлтэс	
2.3.	Гэмт хэрэг үйлдэж болзошгүй болон ял шийтгэгдсэн, ял хойшлогдсон, хорих ял тэнссэн, хорихоос суллагдсан хүмүүсийн судалгааг шинэчлэн гаргаж тэдгээрт тавих захиргааны хяналтыг сайжруулахын зэрэгцээ тэдэнд зориулж “Сургамж” нэвтрүүлэг бэлтгэх, “Захиргааны хяналт” уулзалт зөвлөгөөн, амьдрах ухааны чиглэлээр сургалт, нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулах	Жилдээ	Засаг даргын Тамгын газар Цагдаагийн 1,2-р хэлтэс	
2.4.	Албадан ажил хийлгүүлэх ял шийтгүүлсэн ялтнуудад хууль тогтоомжоор яриа таниулга хийж, ажлын байраар хангах арга хэмжээ авах	Жилдээ	Дүүргийн Засаг дарга Цагдаагийн 1, 2-р хэлтэс	
2.5.	Дүүргийн хуулийн байгууллагуудын хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтарч ажиллах арга замыг тодорхойлох, зөвлөгөөн, ярилцлага, сургалтыг хамтран зохион байгуулах	2-р улиралд	Дүүргийн Прокурор газар	
2.6.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сурталчилгааны	1-р улиралд	Дүүргийн Прокурор газар	

	гарын авлага, шторк зурагт хуудас, санамж зэргийг гарган үйлчилгээний газруудад байрлуулах		Цагдаагийн 1, 2-р хэлтэс Замын Цагдаагийн тасаг Мэргэжлийн хяналтын хэлтэс Онцгой байдлын хэлтэс	
2.7.	Нийтийг хамарсан арга хэмжээнүүдийг угтаж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр машинт эргүүл ажиллуулах.	Тухай бүр нь	Цагдаагийн 1, 2-р хэлтсийн дарга Замын Цагдаагийн тасаг	
2.8.	Хууль бусаар мод бэлтгэх, худалдаалах, байгаль хамгаалах хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, иргэдийн байгаль хамгаалах нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжин ажиллах.	Жилдээ	Мэргэжлийн хяналтын хэлтэс Цагдаагийн 2-р хэлтэс Замын Цагдаагийн тасаг Онцгой байдлын хэлтэс	
2.9.	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх энэ ажилд урамшуулалт морин болон иргэдийн эргүүл ажиллуулах, ойн нөхөрлөлийн үйл ажиллагааг чиглүүлэх	Жилдээ	Дүүргийн Засаг дарга Цагдаагийн 2-р хэлтэс Мэргэжлийн хяналтын хэлтэс Онцгой байдлын хэлтэс	
2.10.	Нийтийн хэв журам бэхжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, СӨХ, "Хөршийн хяналт" иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, тэдний идэвхтэй санал, санаачилга үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах.	Жилдээ	Засаг даргын Тамгын газар Цагдаагийн 1,2-р хэлтэс	
2.11.	Дүүргийн хууль хяналтын байгууллагуудад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж авах	3-р улиралд	Засаг даргын Тамгын газар Прокурорын газар Мэргэжлийн хяналтын хэлтэс Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс Замын Цагдаагийн тасаг	
	"Зуслан" арга хэмжээг зохион байгуулах	6-8-р сард	Цагдаагийн 2-р хэлтэс Замын Цагдаагийн тасаг	
2.13.	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах зорилгоор нээлттэй хаалганы өдрийг нутгийн удирдлагын болон захиргааны байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Улирал бүр	Цагдаагийн 2-р хэлтэс	
2.14.	Зуслангийн аманд мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн борлуулахаар айл, өрх зөвшөөрөлгүй бууж, ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэм, журам зөрчдөг, малын хулгай гардаг байдлыг	2,3-р улиралд	Мэргэжлийн хяналтын хэлтэс Цагдаагийн 2-р хэлтэс Онцгой байдлын хэлтэс	

	таслан зогсоох арга хэмжээ авах			
2.15	Олон нийтийн эргүүлийг тогтмол зохион байгуулах. “Бүх нийтийн эргүүл”, “Оюутан эргүүл” гэх мэт /эргүүл, жижүүрийн тэмдэг, хантаазаар хангах/	Жилдээ	Цагдаагийн 1, 2-р хэлтэс	
2.16	Гал түймэр, гамшгаас урьдчилан сэргийлэх өдөр зохион байгуулах	3-5, 9-11-р саруудад	Онцгой байдлын хэлтэс	
2.17	Иргэд олон нийтийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх болон бусад хуулиуд, шүүхэд нэхэмжлэл хүсэлт гомдол хэрхэн гаргах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн захиргааны үйл ажиллагааны талаар сурталчлах өдөрлөгийг хороодоор зохион байгуулах	2 дугаар улиралд	Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар	
2.18	Гэрч хохирогч хамгаалах түр байрыг хийж тохижуулах, тэнэмэл иргэдийг нийгэмшүүлэх чиглэлээр төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах.	Жилдээ	Засаг даргын Тамгын газар Цагдаагийн 1, 2-р хэлтэс	
Гурав. Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар				
3.1.	Насанд хүрээгүй хүүхдийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Сургууль-Аюулгүй орчин” сэдэвт болзолт уралдаан зарлах, “Гэр бүл аюулгүй орчин” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах	Хагас жилд	Засаг даргын Тамгын газар Цагдаагийн 1, 2-р хэлтэс	
3.2.	Хүүхдийг хөгжүүлэх, хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэншүүлэн төлөвшүүлэх талаар зохион байгуулж байгаа ажил, үр дүнг ЕБС-иудад шалган, танилцаж, зөвлөмж гаргаж, жил бүр уламжлалт “Хүүхэд-хууль”, “Шавийн мэдлэг багшаас”, “Ногоон гэрэл, цагаан шугам” тэмцээн зохион байгуулах, мөн “Өсвөрийн цагдаа” бүлгэм, “Сургууль-аюулгүй орчин”, “Сургуулийн цагдаа” сэдэвт болзолт уралдаан, “Хөвгүүд”, “Охид”, “Багш сурган хүмүүжүүлэгч” зэрэг арга хэмжээг зохион байгуулж, “Хуулийн цаг” зохиомжит нэвтрүүлэг бэлтгэн гаргаж үр дүнг тооцох.	Хагас, бүтэн жилдээ	Засаг даргын Тамгын газар Цагдаагийн 1, 2-р хэлтэс Замын Цагдаагийн тасаг дүүргийн Прокурор газар	
3.3.	Их, дээд сургууль, ЕБС-ийн сурагчдын дунд архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, түүний хор уршгийн тухай эрүүл мэндийн сургалт зохион байгуулах,”	Жилдээ	Дүүргийн Прокурор газар Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар	

	сургууль тамхигүй орчин” хөдөлгөөн өрнүүлж, “school police” хөтөлбөрийн хүрээнд сургалт зохион байгуулах, гар зургийн уралдаан зохион байгуулах.		Цагдаагийн 1, 2-р хэлтэс Мэргэжлийн хяналтын хэлтэс	
3.4.	Гэмт хэрэгт холбогдож болзошгүй насанд хүрээгүй хүмүүсийн судалгааг гаргаж, тэднийг гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Орц”, “Хонгил”, “Траншей”, “Тэнэмэл” арга хэмжээг зохион байгуулах.	1-р улиралд	Цагдаагийн 1, 2-р хэлтэс	
3.5.	Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх дадлага, сургалт, өдөрлөгийг зохион байгуулах.	2 дугаар улиралд	Онцгой байдлын хэлтэс	
3.6.	Хүн ам олноороо төвлөрсөн томоохон худалдааны төвүүдэд гамшиг ослын өдөрлөг, сургалт зохион байгуулах, оюутан сурагчдад сургалт хийх, ногоон бүсэд үзлэг шалгалт хийх, ой хамгаалагчдад болон өндөр барилгаас хүн амь насыг аврах сургалтуудыг зохион байгуулах,	Улирал бүр	Онцгой байдлын хэлтэс	
Дөрөв. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар				
4.1.	Дүүргийн нутаг дэвсгэр дэх хөдөлгөөн зохицуулах тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, замын нөхцөл байдлын үзлэг, тооллого хийж, тэмдэг, тэмдэглэлийг шаардлагатай газарт нь тавиулж, гэрлэн дохио, тэмдэглэлийн хэвийн ажиллагааг хангаж, хичээлийн шинэ жил эхлэхээс өмнө ЕБС, цэцэрлэгийн орчны зам, гарцын тэмдэг, тэмдэглэгээг бүрэн хийлгэх, шаардлагатай газар хурд сааруулагч тавих.	Жилдээ	Дүүргийн Засаг дарга Замын Цагдаагийн тасаг	
4.2.	“Гэмт хэрэг, түүний шалтгаан, түүнээс хэрхэн зайлсхийх нь” “Мансууруулах бодис түүний хор уршиг”, “Архины хор нөлөө, архи дан согтуурахын хор уршиг” зэрэг сургалтуудыг ерөнхий боловсролын 10-12 дугаар ангийн сурагчдад хийх	Жилдээ	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар	
4.3.	“Цагаан шугам”, “Хамгаалах бүс”, “Согтуу жолооч” болон бусад аяныг тусгай удирдамжийн дагуу зохион байгуулж дүгнэх.	Жилдээ	Замын Цагдаагийн тасаг	
4.4.	Явган зорчигч зам хөндлөн гарах, тээврийн хэрэгсэл бусдад саад учруулан буцаж эргэх болон үргэлжилсэн цагаан шугам давахаас сэргийлэх зорилгоор хайс, хашлага хийлгэх.	2-3-р улиралд	Замын Цагдаагийн тасаг	

4.5.	Алслагдсан байршлуудад хяналтын камеруудыг гэрэлтүүлгийн хамт тавих.	Жилдээ	Дүүргийн Засаг дарга Замын Цагдаагийн тасгийн дарга	
4.6.	Олон нийтийн байцаагч ажиллуулах	2 дугаар улиралд	Замын Цагдаагийн тасгийн дарга	
Тав. Архидан согтуурахтай тэмцэх, хяналт тавих талаар				
5.1.	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, “Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр”, “Сар бүрийн 01-н архигүй өдөр” шийдвэрийн хэрэгжилтийг хангаж үр дүнг тооцож ажиллаж, архинд донтох өвчтэй болон орчиндоо байнга түгшүүр төрүүлдэг архаг архичдын судалгааг шинэчлэн гаргаж, сайн дурын болон албадан эмчилгээ, сургалтад хамруулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, нийгэмшүүлэх	Жилдээ	Засаг даргын Тамгын газар Цагдаагийн 1, 2-р хэлтэс Мэргэжлийн хяналтын хэлтэс Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар	
5.2.	Гэр бүл, үр хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор “Хамтарсан баг”, “Гэр бүл-Аюулгүй орчин”, “Хөршийн хамгаалалт” нэгдсэн арга хэмжээг ТББ-тай хамтран зохион байгуулах.	Жилдээ	Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс	
5.3.	Хууль бусаар архи, спирт үйлдвэрлэж борлуулдаг иргэдийн судалгааг нарийвчлан гаргаж холбогдох арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх архи, согтууруулах ундааны хууль бус зар сурталчилгаанд тавих хяналтыг чангатгах.	Жилдээ	Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс Мэргэжлийн хяналтын хэлтэс	
5.4.	Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох явдалтай хийх тэмцлийг эрчимжүүлж, авах арга хэмжээг чангатгаж энэ төрлийн зөрчлийг таслан зогсоох ажлыг зохион байгуулж, олон нийтэд тогтмол мэдээлж ажиллах.	Жилдээ	Замын Цагдаагийн тасаг	
5.5.	Согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуй нэгжүүдэд үзлэг, шалгалтыг тогтмол явуулж Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль бусад хуулийн болон нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын хэрэгжилтийг ГХУСА33-д тайлагнах.	Жилдээ	Газар, хэлтэс, тасгууд	

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ.